



МОНГОЛЫН
ГЭР БҮЛИЙН
САЙН САЙХНЫ
НИЙГЭМЛЭГ



МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ

2016-2022

НҮБ-ЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ЗӨВЛӨЛТЭЙ ОНЦГОЙ ЗӨВЛӨЛДӨХ СТАТУСТАЙ МОНГОЛ УЛС ДАХЬ АНХНЫ ТББ



**МОНГОЛЫН ГЭР
БҮЛИЙН САЙН САЙХНЫ
НИЙГЭМЛЭГ**



Баянгол дүүрэг, 10-р
хороолол, 5-р хороо
89/3-р байр, 2 давхарт
Улаанбаатар хот,
Монгол улс



+976 70183514
+976 70186180



info@mfa.mn



www.mfa.mn



mfa.mn

ӨМНӨХ ҮГ

Бэлгийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар 22 жил тууштай ажиллаж буй Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн хамт олон, гишүүд, дэмжигчдийн хүчин зүтгэл нь БНҮЭМ-ийг сайжруулах, НҮЭМ-ийн 4 дэхь үндэсний хөтөлбөр, БЗДХ/ХДХВ/ДОХ-той тэмцэх үндэсний стратеги, Үр хөндөлтийн үндэсний стандарт зэргийг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан нь дамжиггүй.

Нийгэмлэг нь 2011-2015 онд 99.520 өсвөр үеийнхэн, залуучуудад БНҮЭМ, бэлгийн амьдрал, эрхийн талаар мэдээлэл, мэдлэг түгээж, 243.870 хүнд БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлсэнээр БНҮЭМ-ийн мэдлэг боловсрол, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж залуучуудын оролцоонд суурилсан Залуучуудын Үе Тэнгийн Боловсролын Үндэсний Сүлжээг (Ү-PEER) өргөжүүлэн чадваржуулж, мэдээлэл харилцааны шинэлэг арга хэлбэрүүдийг нэвтрүүлж, эмнэлгүүд үндэсний стандартын шаардлага ханган магадлан итгэмжлэгдэж, БНҮЭМ-ийн үндсэн тусламж үйлчилгээг нэг цэгээс багцаар нь үзүүлдэг боллоо. Нийгэмлэг нь 2015 онд анх удаагаа НҮБ-ын нийгэм эдийн засгийн зөвлөлтэй онцгой зөвлөлдөх статустай Монгол улс дахь анхны ТББ боллоо.

Үндэсний болон олон улсын байгууллагуудтай тухайлбал Эрүүл мэндийн яам, Өргөө амаржих газар, Өвөрхангай БОЕТ, ЭМЗ, ЗДТГ, ЭХЭСХҮТ, БОЭТ, БНХАУ-ын Гэр бүл төлөвлөлтийн нийгэмлэг, Аюулгүй үр хөндөлтийн тусламжийн сан, жирэмслэхээс хамгаалах олон улсын сан, Гэр бүл төлөвлөлтийн асуудлаарх Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн харилцан ойлголцлын санамж гэрээ байгуулан БНҮЭМ-ийн боловсрол олгох, тусламж үйлчилгээний цар хүрээгээ нэмэгдүүлэн ажиллаж байна.

Бид 2016-2022 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөгөө ажилтнууд, гишүүд, дэмжигчид, оролцогч талуудынхаа оролцоотойгоор 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн зорилтууд, ОУГБТХ-ны 2022 он хүртэлх стратеги зорилтуудтай уялдуулан боловсрууллаа.

Мөн дотооддоо тодорхой хэмжээний хөрөнгө нөөц бүрдүүлэн цаашид хандивлагчаас хараат бус байх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Бидний үйл ажиллагааг байнга дэмжиж тусалж байдаг хандивлагчид болон хамтрагч түнш байгууллагууддаа болон стратеги төлөвлөгөө боловсруулахад санхүүгийн болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн ОУГБТХ-ны Зүүн ба зүүн өмнөд ази далайн бүсийн төвийн удирдлага, хамт олонд гүн талархал илэрхийлье!

Стратеги төлөвлөгөөг боловсруулахад гүн туслалцаа үзүүлж идэвхтэй оролцсон Удирдах зөвлөлийн гишүүд, салбарын тэргүүн, сайн дурын идэвхтнүүд, үе тэнгийн сургагч багш зөвлөгчид, ажилтнууд болон АУ-ны доктор, НҮЭМ-ийн зөвлөх Х.Энхжаргал нарт онцгойлон талархал илэрхийлж эрүүл энх, амжилт бүтээл хүсье!

Энэхүү стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэн идэвх зүтгэлтэй санаачлагатай ажиллахыг гишүүд, дэмжигчид, идэвхтнүүд, ажилтнууддаа уриалж байна.

Танд болон танай гэр бүлд эрүүл энх, аз хийморь, амжилт бүтээл хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн,



**ЕРӨНХИЙЛӨГЧ
Б. ГАНБОЛД**



**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б. МӨНХЦЭЦЭГ**

МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсын суурин хүн амын тоо 2015 оны жилийн эцсийн байдлаар 2990.2 мянга бөгөөд хүн амын 49 хувийг эрэгтэйчүүд, 51 хувийг эмэгтэйчүүд, 30 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 17 хувийг 15-24 насны, 18 хувийг 25-35 насны, 20 хувийг 35-49 насны, 15 хувийг 50 буюу түүнээс дээш насны хүн ам тус тус эзэлж байна.¹

Манай улсын таван хүн тутмын нэг нь ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай байгаа ба хүн амын амьжиргааны түвшин хот, хөдөөд ихээхэн ялгаатай байна. Гэсэн хэдий ч Монгол Улс нь үндэсний түвшиндээ Хүний хөгжлийн индекс 0.727 болсон нь дэлхийн 188 улсаас 90-д бичигдэж хүний хөгжлийн түвшин өндөртэй орнуудын ангилалд шилжив.²

Жендэрийн тэгш бус байдлын индекс 0,325 байгаа нь дэлхийн 155 улсаас 63-т орж байна. Жендэрийн тэгш бус байдлын индекс буурч байгаа нь эмэгтэй эрэгтэй хүмүүс боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамрагдаж байгаагийн илрэл юм.³

Нэг хүнд ноогдох ДНБ нь 2006 онд 1300 ам.доллар байсан бол 2014 оны байдлаар 4055 ам.доллар болж өсжээ.⁴

Монгол улс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 3 шатлалт тогтолцоотой бөгөөд улсын хэмжээнд нийт 3244 төрийн, хувийн хэвшлийн ба холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаагаас 1006 үүдэн эмнэлэг тусламж үйлчилгээ үзүүлж байна.⁵

Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд хүүхдийн эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийг сайжруулах, ХДХВ/ДОХ, сүрьеэ өвчинтэй тэмцэх гэсэн эрүүл мэндийн 3 зорилго дэвшүүлснээс 2015 оны байдлаар улсын хэмжээнд нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 15.3, нярайн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 10.2 байсан ба эхийн эндэгдлийг тогтвортой бууруулснаар 100 000 амьд төрөлтөд 26.0 болгож 1990 оныхоос 7.6 дахин бууруулжээ. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон Дэлхийн банкнаас хамтран хийсэн “Эхийн эндэгдлийн хандлага 1990-2015” судалгаагаар Монгол улс Мянганы хөгжлийн эхийн эндэгдлийг бууруулах зорилтод хүрсэн 9 орны нэг болсон байна.



Өсвөр насныхны төрөлтийн түвшин өндөр байгаа бөгөөд 2013 оны байдлаар 1000 хүнд 40.4 төрөлт ногдож байна. Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл хэрэглэх түвшин 2003 онд 69 хувь байсан бол 2013 онд 54.6 хувь болж буурсан байна. Гэр бүл төлөвлөлтийн хэрэгцээ 2003 онд 4.6 хувь байснаас 2013 онд 16 хувь болтол өсч, ялангуяа 15-19 (36.4%) насны болон хот сууринд газруудад амьдардаг эмэгтэйчүүдийн дунд өндөр байна. Ялангуяа үр хөндөлт нэмэгдэж, 2008 онд 1000 төрөлтөд 169 байснаас 2013 онд 205 болсон нь (258.2 хот суурин, 129.8 хөдөө орон нутагт) сэтгэл түгшээж байна. Мөн 15-24 насны залуу 10000 хүн тутамд тэмбүүгээр өвчлөгсөд 60.4 хувь, 25-49 насныханд 32 хувь байгаа нь өндөр үзүүлэлт юм.⁶

2016 оны 5 дугаар сарын байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 210 тохиолдол бүртгэгдэж, ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 79,8% нь эрэгтэйчүүд (гей 48.4%, бисекс 29%, трансжендер 1.2%, гетеросекс 21.2%), 19,6% нь эмэгтэйчүүд байна. Насны хувьд авч үзвэл 18,6 % нь 15-24, 43,5% нь 25-35, үлдсэн 38 хувь нь 35-аас дээш насны хүмүүс байна.⁷

МОНГОЛ УЛС ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ 2030–Д НӨХӨН ҮРЖИХҮЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР,
ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИЖ ЭХ ХҮҮХДИЙН
ЭНДЭГДЛИЙГ ТОГТВОРТОЙ БУУРУУЛЖ
ЭХИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИНГ 100000 АМЬД
ТӨРӨЛТӨД 15, ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН
ЭНДЭГДЛИЙН ТҮВШИНГ 1000 АМЬД ТӨРӨЛТӨД
9, НЯЛХСЫН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИНГ 1000 АМЬД
ТӨРӨЛТӨД 8 БОЛГОХ ЗОРИЛТ ТАВЬСАН БАЙНА.

1. Монгол улсын статистикийн эмхтгэл; 2. 2015 Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2015 3. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2015; 4. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2015; 5. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2015; 6. НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ 2017-2021, Монгол улс, 2016; 7. ХӨСҮТ, ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба 2016 оны 5 сар

2011-2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГОЛ ҮР ДҮН БА ЗӨВЛӨМЖ

1 Тус нийгэмлэг нь 2011-2015 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөндөө бэлгийн ба нөхөн үржихүйн эрх болон БНҮЭМ-ийн талаар Монгол улсын шийдвэрлэвэл зохих тулгамдаж буй асуудлуудыг зөв зүйтэй харж, тэдгээрийг шийдэхэд хувь нэмрээ оруулахыг зорьсоноороо тус стратеги төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтууд, шийдэх арга замууд нь үндэсний бодлого, нөхцөл байдал хийгээд Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны бодлого, зорилго, тэргүүлэх чиглэлүүдтэй бүрэн нийцэж байна.

2 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд буюу 2011-2015 онд тус байгууллага нь өөрийн баг, салбарууд, гишүүд, дэмжигчид, идэвхтнүүдийн хүчин чармайлтаар ойролцоогоор 99.520 өсвөр үеийнхэн, залуучуудад БНҮЭМ, бэлгийн амьдрал, эрхийн талаар мэдээлэл, мэдлэг түгээж, 243.870 хүнд БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлсэнээр БНҮЭМ-ийн мэдлэг боловсрол, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулжээ.

3 БНҮЭМ-ийн мэдээлэл, мэдлэг түгээх чиглэлээр залуучуудын оролцоонд суурилсан Y-PEER үндэсний сүлжээг өргөжүүлэн чадваржуулж, мэдээлэл харилцааны шинэлэг арга хэлбэрүүдийг нэвтрүүлсэн, БНҮЭМ-ийн тусламж үзүүлдэг эмнэлгүүд нь үндэсний стандартын шаардлага ханган магадлан итгэмжлэгдсэн, БНҮЭМ-ийн үндсэн тусламж үйлчилгээг нэг цэгээс багцаар нь үзүүлдэг, дийлэнхи үйлчлүүлэгч нь 2-4 удаа үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчид байгаа зэргээс харахад БНҮЭМ-ийн мэдээлэл, мэдлэг, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад зохих ахиц гарсныг харуулж байна.

4 БНҮЭМ-ийн бодлого эрхзүйн дэмжлэгт орчныг бүрдүүлэхийн төлөө УИХ-ын зарим гишүүд болон зорилго нэгт байгууллагуудтайгаа хамтран зохих хүчин чармайлт тавьснаар “Садар самуунтай тэмцэх тухай”, “ХДХВДОХ-оос сэргийлэх тухай” Монгол Улсын хуулиудад бэлгийн ба нөхөн үржихүйн эрхийг хамгаалах чиглэлээр эерэг өөрчлөлт хийхэд нөлөөлж, мөн Гамшгийн үеийн НҮЭМ-ийн асуудлыг Эрүүл мэндийн салбарын гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулсан зэрэг нь ухуулга нөлөөллийн талаарх зорилт зохих үр дүнд хүрснийг илтгэж байна.

5 Санхүүгийн нөөцөө нэмэгдүүлэх, хүний нөөцөө чадваржуулахад боломжийнхоо хэмжээнд сайн анхаарсан, олон улсын магадлан итгэмжлэгдсэн ТББ болсноор тус нийгэмлэгийн ОУГБТХ дэх байр суурь улам бэхжсэн, эрүүл мэндийн салбар дахь иргэний нийгмийн оролцоонд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн зэрэг нь сайшаалтай байна.

НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖҮҮД

1 ӨӨРЧЛӨЛТӨД МЭДРЭМЖТЭЙ ХАНДАХ
Монгол Улсад өнөөдөр бүх хүрээнд өөрчлөлт шинэчлэлт эрчимтэй, хурдацтай явагдаж байна. Иймд тус нийгэмлэг шинэ стратегиа боловсруулахдаа, гадаад дотоод орчин, боломж хийгээд эрсдлээ сайтар судалж, өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг харгалзан өрсөлдөх чадвараа үнэлэх хэрэгтэй.

2 ЧУХАЛ АСУУДЛУУДАА ЭРЭМБЭЛЭХ
Тус стратеги төлөвлөгөө нь зарим нэгэн өргөн цар хүрээтэй асуудлуудыг хязгаарлагдмал нөөцөөр шийдэхийг оролдож, үр дүнг нь хэмжих, дүгнэхэд төвөгтэй, тодорхой бус, ерөнхий зорилтууд дэвшүүлсэн тал байна. Цаашид тус нийгэмлэг нь байгууллагынхаа зорилгод нийцсэн, хамгийн чухал асуудлуудад анхаарлаа төвлөрүүлж, ач холбогдлоор нь эрэмбэлж, хүрч болох, хэмжигдэхүйц, тодорхой зорилтуудыг дэвшүүлэхэд анхаарвал зохино.

3 ХААНА, ХЭНД ХҮРЭХЭЭ БОДИТОЙ СОНГОХ
Хязгаарлагдмал нөөцтэй байгууллага, “орон даяар” үйл ажиллагаа явуулах нь нөөцөө тарамдах, үйл ажиллагааны чанар, үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Иймээс тус нийгэмлэг нь үйл ажиллагааны байршил, зорилтот хүн амаа эргэн харж, байгаа нөөц боломжид тань зохистой эсэхийг нягталж, үндэслэлтэй сонгох хэрэгтэй. Өсвөр үеийнхэн, залуучуудад хандсан үйл ажиллагаагаа өргөжүүлэх, эрсдэлт бүлгийнхэнд хүрч ажиллах хөтөлбөр хэрэгжүүлэх нь илүү зохистой бөгөөд үр дүнтэй байж болох юм.

4 СТРАТЕГИЧ АРГА БАРИЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
Тогтвортой байдал ба хөтөлбөрийн санхүүжилт нь цаашдын ололт амжилтын гол тулгамдсан асуудал гэж үзэж байна. Иймд тус нийгэмлэг нь “төслөөс гарах” стратегийг боловсруулж, “донороос хараат байдал”-аа үе шаттайгаар багасгаж, тогтвортой үйл ажиллагаагаа хангах шаардлага тавигдаж байна. Цаашилбал аливаа төслийн тогтвортой ажиллагаа болон байгууллагын хөгжилтэй хэрхэн зохицож байгааг төлөвлөж байх үеэсээ анхаарах хэрэгтэй. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ, хүрэх хүний тоог нэмэгдүүлэхээсээ, илүү стратегийн шинжтэй, үр дүнтэй үйл ажиллагааныхаа эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх, “бренд үйл ажиллагаа, үйлчилгээгээ” улам өргөжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Үйлчилгээнийхээ маркетингийг идэвхжүүлэх, ашгийн бус нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх, нийгмийн маркетинг, франчайзингийн аргуудыг хэрэглэх зэргээр шинэ стратегийн ач холбогдолтой арга замуудыг эрэлхийлэх хэрэгтэй.

5 БАГА ЗАРДЛААР ӨНДӨР ДҮНД ХҮРЭХ
Сайн дурын идэвхтнүүдээр ЖСА хэрэгслийг олон нийтэд түгээх, Y-PEER клубүүдээр залуучуудад хүрэх гэх мэт одоо хэрэглэж буй бага зардлаар илүү үр дүнд хүрэх стратегиудаа өргөжүүлэх нь чухал. Үүний тулд, эдгээр стратегийн менежментийг сайжруулж, тогтвортой байдлыг нь хангах, бусад өртөг багатай аргуудыг нэвтрүүлвэл сайн байна.

6 ЗАН ҮЙЛИЙГ ӨӨРЧЛӨХ ХАРИЛЦААНЫ ЧАДАВХАА САЙЖРУУЛАХ
Монголд БНҮЭМ-ийн асуудлаар хүн амын ерөнхий ойлголт харьцангуй сайн ч “үнэн зөв мэдлэг”, “мэдлэгээ хэрэглээ болгох” талаар ихээхэн зөрүү байгааг судалгааны дүнгүүд харуулсаар байгаа. Иймд зан үйлийг өөрчлөх талаар байгууллагынхаа чадавхийг дээшлүүлэхэд анхаарах, нийт хүн амд ерөнхий мэдээлэл түгээхээс илүүтэй зорилтот бүлэгт хандсан зан үйлийг өөрчлөх харилцааны үйл ажиллагаанд түлхүү анхаарвал зохино.

7 СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛЭЭ БЭХЖҮҮЛЭХ
Хөрөнгө босгох, бэлгийн ба нөхөн үржихүйн эрхийн асуудлаар нотолгоонд суурилсан ухуулга хийх, БНҮЭМ-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагууд, хувийн хэвшил, МСҮТ, их дээд сургуулиуд зэрэг боловсролын байгууллагууд, зорилго нэгт иргэний нийгмийн байгууллагуудтайгаа стратегийн түншлэл тогтоох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай. МГБССН нь сайн засаглалтай, нээлттэй, биеэ даасан, хараат бус, өрсөлдөх чадавхи сайтай, Монголдоо БНҮЭМ-ийн салбарт манлайлагч ТББ байгууллага байх боломж нээлттэй бөгөөд ойрхон байгааг харахад таатай байлаа.



MERCADO МАРКЕТИНГИЙН ЗӨВЛӨХ КОМПАНИЙ ХИЙСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНААС



ГЭР БҮЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СУДАЛГАА

"Гэр бүл" эмнэлгээр ихэвчлэн 23-27 насны хүмүүс 3-4 удаа давтан үйлчлүүлж байгаа нь үйлчилгээний орчин нөхцөл ажилтнуудын харилцаа, мэдлэг, чадварт сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна. Гэр бүл эмнэлгийн талаарх мэдээллийг ихэвчлэн байгууллагын гадна хаяг болон гэр бүл, ойр дотныхоо хүмүүсээс авдаг байна. Ингээд судалгааны үр дүнгээс дараах гурван зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

Мэдээлэл. Эмнэлгийн гадаад хаягжилтыг сайжруулж үйлчилгээний төрөл ангиллыг дэлгэрэнгүй харуулсан мэдээлэл дотоод орчинд байршуулан нийт ажилтнуудын үйлчилгээний талаар мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх

Үйлчилгээний стандарт. Үйлчлүүлэгчийг угтах үйлчилгээг сайжруулан, ажилтнуудын цаг ашиглалт, үйлчилгээний хурдыг нэмэгдүүлэхийн тулд стандарт боловсруулан үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах

Бодлого. Идэвхжүүлэлтийн тогтмол хөтөлбөртэй болж байнгын үйлчлүүлэгчдийг урамшуулах бодлого боловсруулан цахим орчинд мэдээ, мэдээллийг оновчтой байршуулах



АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Ажилтнуудыг сэтгэл ханамжтай ажиллуулахын тулд анхаарах зүйлс:

Хувь хүний хөгжил дэвшилд анхаарч сургалтад хамруулах

Байгууллагын дотоод уур амьсгалыг сайжруулах хөтөлбөрүүдийг үе шаттай зохион байгуулах

Нийгэмлэгийн ажилтнуудын эрүүл мэндэд анхаарч үнэ төлбөргүй вакцинд хамруулах




ГИШҮҮДИЙН ЗАН ТӨЛӨВ, ХАНДЛАГЫН СУДАЛГАА

Гишүүдийн судалгаанаас харахад дийлэнх нь 40-с дээш настай болон ихэвчлэн эрүүл мэндийн байгууллагад ажилладаг болох нь харагдаж байна. Гишүүдийн хувьд үйл ажиллагаагаа сайжруулах, үр дүнтэй явуулахад хамгийн түрүүнд хөрөнгө санхүү, ажиллах орчин нөхцөлийн асуудлыг шийдвэрлэх ёстой гэж үзсэн боловч мөн гишүүд хоорондын уялдаа холбоо туршлага солилцох, сургалт семинарыг байнга зохион явуулах гишүүнчлэлийг дахин шинэчлэх, гишүүдтэйгээ байнгын харилцаа холбоотой мэдээ мэдээлэл, сургалтын материал, хэрэглэгдэхүүнээр хангах, нийгэмлэгийг иргэд болон албан байгууллагуудыг хамарсан томоохон хэмжээний компанит ажил явуулж сурталчлан таниулах шаардлагатай байна гэж үзжээ.


МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ

ХҮН БҮРИЙН ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН, СОНГОЛТ
ХИЙХ БОЛОМЖТОЙ ЭРҮҮЛ НИЙГМИЙН ТӨЛӨӨ





АЛСЫН ХАРАА
ХҮН БҮРИЙН ЭРХИЙГ
ДЭЭДЭЛСЭН, СОНГОЛТ
ХИЙХ БОЛОМЖТОЙ
ЭРҮҮЛ НИЙГМИЙН
ТӨЛӨӨ



Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг нь 1994 онд байгуулагдсан, сайн дурын, ашгийн бус, нам бус, шашны бус, төрийн бус байгууллага юм. МГБССН нь 1996 онд Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны туслах гишүүнээр элсэж 2005 онд жинхэнэ гишүүн нийгэмлэг болж 2010 онд хоёр дахь удаагаа олон улсад магадлан итгэмжлэгдсэн байгууллага юм.

МГБССН нь ОУГБТХ-ны санхүүгийн тусламж дэмжлэгтэйгээр төсөл боловсруулж хэрэгжүүлэх замаар үйл ажиллагаагаа явуулдаг. Мөн НҮБ-ын Хүн амын сан, аюулгүй үр хөндөлтийн тусламжийн сан, жирэмслэхээс хамгаалах олон улсын сан, Гэр бүл төлөвлөлтийн асуудлаарх Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, БНХАУ-ын гэр бүл төлөвлөлтийн нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагууд, үндэсний, төрийн ба төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.

ЭРХЭМ ЗОРИЛГО
ХҮН БҮРТ БНҮЭМ БА ЭРХИЙН
БОЛОВСРОЛ, ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ, ТЭГШ,
ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭХЭД
МАНЛАЙЛНА.



ҮНЭТ ЗҮЙЛС

1. Эрхийг дээдэлсэн
2. Чанартай найдвартай
3. Түншлэл нэгдмэл
4. Сайн дурын гишүүд дэмжигч
5. Хариуцлага ил тод байдал

МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ НИЙГЭМЛЭГ НЬ 2015 ОНД НҮБ-ЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ЗӨВЛӨЛТЭЙ ОНЦГОЙ ЗӨВЛӨЛДӨХ СТАТУСТАЙ МОНГОЛ УЛС ДАХЬ АНХНЫ ТББ БОЛЛОО.

2014 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн НҮБ-ын Нийгэм эдийн засгийн зөвлөлийн дэргэдэх ТББ-уудын хэлтэст Нэгдсэн үндэстний байгууллагын нийгэм, эдийн засгийн зөвлөлдөх статустай ТББ болох өргөдлөө гаргаж

НҮБ-ын нийгэм эдийн засгийн зөвлөлийн дэргэдэх ТББ-уудын хороо нь АНУ-ын Нью Йорк хотноо 2015 оны 1 дүгээр сарын 26-наас 2 дугаар сарын 4-ний хооронд хуралдаж МГБССН-ийг НҮБ-тай нийгэм эдийн засгийн онцгой зөвлөлдөх статустай ТББ болгох санал, шийдвэрээ НҮБ-ын Нийгэм эдийн засгийн зөвлөлийн 2015 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралд танилцуулан уг хурлаар баталгаажсанаар МГБССН нь албан ёсоор НҮБ-тай онцгой зөвлөлдөх статустай Монгол улс дахь анхны ТББ болсон юм.

Бид НҮБ-ын нийгэм эдийн засгийн зөвлөлтэй онцгой зөвлөлдөх статустай ТББ болсноор тодорхой асуудлуудад мэргэжлийн зөвлөгөө зөвлөмж өгөх, сэрэмжлүүлэх үүрэг гүйцэтгэх, олон улсын гэрээ конвенциудын хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийх, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, АНУ-ын Нью Йорк, Австри улсын Вена, Швейцарын Женев хотод НҮБ-ын үндсэн байранд зохиогддог хүн ам хөгжлийн асуудал, эмэгтэйчүүдийн аж байдал, тогтвортой хөгжил, нийгмийн хөгжил, шинжлэх ухаан технологийн хөгжил зэрэг асуудлаарх олон улсын хуралд оролцож иргэний нийгмийн байр суурийг амаар болон бичгээр илэрхийлэх, тодорхой асуудлаар нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, бусад олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах, сүлжээнд нэгдэх зэрэг боломжтой болсон билээ.

ЗОРИЛГО (ҮР ДҮН) 1: БНҮЭМ БА ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ДЭМЖЛЭГТ ОРЧИН БҮРДСЭН БАЙНА.



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: ШИНЭЭР БАТЛАГДСАН БОЛОН ЭЭРЭГ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ (ТОО)

ЗОРИЛТ 1

БНҮЭМ ба эрх, жендэрийн асуудлаарх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг манлайлах

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

3-аас доошгүй хууль эрх зүйн акт шинээр батлагдсан буюу нэмэлт өөрчлөлт орсон байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

БНҮЭМ ба эрх, жендэрийн асуудлаарх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дараах нөлөөллийн ажлуудыг хийнэ:

- ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт БНҮЭМ-ийн хичээлийг бие даасан хичээл болгоход нөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлнэ
- Үүдэн эмнэлгүүдийн үйлчилгээг ЭМ-ийн даатгалд хамруулахад нөлөөлөх ажлын хэсэг байгуулна
- Аюулгүй үр хөндөлтийн тусламж үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн ТББ-ын/ хувийн хэвшлийн эмнэлгүүдээр үзүүлэх тусгай зөвшөөрлийг олгох асуудлуудаар холбогдох хууль, эрхзүйн баримт бичгүүдэд өөрчлөлт оруулахад нөлөөлөх ажлын хэсэг байгуулна.
- Дээрх ажлын хэсгүүд төлөвлөгөө гарган ажиллах;
- Холбогдох хууль, эрхзүйн баримтын судалгаа хийх;
- Баримтын хуудас боловсруулж, хэвлүүлэх;
- Оролцогч талуудтай уулзалтууд зохион байгуулах
- Эрх барих дээд байгууллагуудын шийдвэр гаргагчид, удирдлагуудтай нөлөөллийн уулзалт арга хэмжээ зохион байгуулах

ЗОРИЛТ 2

БНҮЭМ ба эрх, жендэрийн асуудлаархи манлайлагч-ухуулагчдыг бэлтгэн чадваржуулах

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Сургагдсан, идэвхтэй ажиллаж буй манлайлагч-ухуулагчдын тоо

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Боловсрол тусламж үйлчилгээг чанаржуулах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэгт орчинг бий болгох, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэмжлэгт орчинг бүрдүүлэхэд нөлөөлөх манлайлагч-ухуулагчдын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулж ажиллуулах

- Олон улсын болон өөрийн орны ижил төстэй манлайлагч-ухуулагчдын хөтөлбөрүүдийг судлах;
- Манлайлагч-ухуулагчдын хөтөлбөр болон дагалдах баримт бичгүүдийг боловсруулах, турших, эцэслэх;
- Хөтөлбөрөөр сургалт зохион байгуулж, жил бүр 20-40 манлайлагчийг сургаж бэлтгэх;
- Эрүүл мэндийн байгууллагуудын нийгмийн ажилтнууд, өрхийн эмнэлгийг түшиглэн манлайлагч-ухуулагчдыг бэлтгэх.
- Давтан сургалт зохион байгуулах, манлайлагчдыг дэмжиж ажиллах; Манлайлагч-ухуулагчдын туршлага солилцох уулзалтыг жил бүр зохион байгуулах;
- Манлайлагч-ухуулагчдын хөтөлбөрийн үр дүнг үнэлэх
- Залуучуудыг татан оролцуулж нийгмийн хөдөлгөөн/ давалгаа үүсгэх.

ЗОРИЛГО (ҮР ДҮН) 2:
1,300,000 ХҮНД, ТҮҮНИЙ
ДОТОР 15-34 НАСНЫ ӨСВӨР
ҮЕ, ЗАЛУУЧУУД БНҮЭМ
БА ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ
АВЧ, МЭДЛЭГ, УР ЧАДВАР
ЭЗЭМШСЭН БАЙНА.



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:
БНҮЭМ БА ЭРХИЙН
МЭДЭЭЛЭЛ АВСАН,
МЭДЛЭГ, УР ЧАДВАР
ЭЗЭМШСЭН ХҮНИЙ ТОО

ЗОРИЛТ 1

15-34 насны өсвөр үе залуучуудад БНҮЭМ ба эрхийн мэдээлэл, мэдлэг, ур чадвар олгох шинэлэг аргуудыг нэвтрүүлэх

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Шинээр нэвтрүүлсэн шинэлэг аргуудын тоо,

- Үйл ажиллагаанд хамрагдсан өсвөр үе, залуучуудын тоо
- Цахим хуудсаар мэдээлэл авсан хүний тоо
- Цахим сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан хүний тоо

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

БНҮЭМ ба эрх, жендэрийн асуудлаарх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дараах нөлөөллийн ажлуудыг хийнэ:

- Өсвөр үе залуучуудад БНҮЭМ, эрх-ийн мэдээлэл, мэдлэг, ур чадварыг өөрөө олж авах, өөрийгөө үнэлэх онлайн сургалтыг зохион байгуулна.
- Онлайн суурилсан сургалтын арга хэрэгслүүдийг боловсруулах.
- Онлайн сургалтанд хамрагдсан өсвөр үе, залуучуудад гэрчилгээ олгох
- цаашид ҮТС-аар чадваржуу-лан бэлтгэх.
- Онлайн сургалтын туршлагыг судлах, нэвтрүүлэх.
- Олон улсад туршигдаж амжилттай хэрэгжиж буй бусад шинэлэг аргуудыг судалж нэвтрүүлэх
- Зорилтот бүлэгт чиглэсэн Мэдээлэл сургалт сурталчилгааны материалыг шинэлэг хэлбэрээр боловсруулхад хувь нэмрээ оруулах.

ЗОРИЛТ 2

БНҮЭМ, эрхийн асуудлаар үе тэнгийн боловсролын загвар хөтөлбөр боловсруулж үндэсний хэмжээнд нэвтрүүлэх

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- Загвар хөтөлбөр эрх бүхий байгууллагаар батлагдсан эсэх
- Бэлтгэгдсэн ҮТС, ҮТС багш нарын тоо, тэдний мэдээлэл түгээсэн хүний тоо
- Ү PEER сүлжээний үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Өсвөр үе залуучуудын БНҮЭМ, эрхийн асуудлаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, хэрэгцээг тодорхойлох;

- Ү PEER сүлжээний клубын тоог нэмэгдүүлэх,
- Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, механизмийг бүрдүүлэх;
- БНҮЭМ, эрхийн асуудлаарх үе тэнгийн боловсролыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх загвар хөтөлбөр боловсруулж турших,
- Холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах
- Загвар хөтөлбөр өөр ҮТС, ҮТС багш нарыг үе шаттайгаар бэлтгэх, дэмжиж ажиллах;
- Загвар хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж үнэлэх;
- Сайн туршлагуудыг баримтжуулах, туршлага солилцох нэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах
- ҮТС нарыг урамшуулах, үнэлэх механизмыг боловсронгуй болгох.
- Олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг хариуцаж хийх.

ЗОРИЛГО (ҮР ДҮН) 3: 1,600,000 ХҮН БНҮЭМ-ИЙН ЧАНАРТАЙ, ЦОГЦ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТСЭН БАЙНА.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: БНҮЭМ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТСЭН ХҮНИЙ ТОО

ЗОРИЛТ 1

БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээний нэр төрөл,
хамрах хүрээг нэмэгдүүлэх

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээний тоо
- Үүнээс:
 - - Шинээр нэвтрүүлсэн
 - БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо
- Үүнээс:
 - -БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээ авсан эмзэг бүлгийн хүмүүсийн хувь
 - -ГБТ-ийн зөвлөгөө авсан:
 - -ЖСАХ-ээр үйлчилсэн:
 - -БЗДХ-ийн оношилгоо, эмчилгээ хийлгэсэн:
 - -СДИ хүрч үйлчилсэн:
 - -Явуулын тусламж үйлчилгээ авсан:
 - Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- БНҮЭМ ба эрхийн чиглэлээр СДИ-нүүдийн хөдөлгөөн өрнүүлэх,
- өргөжүүлэх, уулзалт, арга хэмжээ зохион байгуулах;
- ЭМЯ, эрүүл мэндийн байгууллагуудтай явуулын тусламж үйлчилгээг өргөжүүлэх асуудлаар нөлөөллийн уулзалтууд зохион байгуулах;
- Хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах;
- ГБТ-ийн үйлчилгээг өргөжүүлэх;
- БНҮЭМ-ийн асуудлаар сэтгэл зүйн зөвлөгөөг онлайнаар, утсаар болон биечлэн өгөх үйлчилгээг нэвтрүүлэх талаар судалгаа, тооцоо хийх
- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх

ЗОРИЛТ 2

Хөвгүүд, эрчүүдэд зориулсан БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Тусламж үйлчилгээнд хамрагдсан хөвгүүд, эрчүүдийн тоо:
Үүнээс:

- 15-24 насны
- Хөвгүүд эрчүүдэд зориулсан тусламж үйлчилгээний тоо

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Эрчүүд, өсвөр насны хөвгүүдийн дунд БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээний үнэлгээ хийх;
- Эрчүүд, ялангуяа өсвөр насны хөвгүүдэд зориулсан БНҮЭМ-ийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах багаж, эм хэрэгсэлийг худалдан авах, хүний нөөцийг бэлтгэх, ажлын байр гаргах зэрэг үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Эрчүүд, хөвгүүдэд зориулсан БНҮЭМ-ийн мэдээлэл, зөвлөгөө, сургалт сурталчилгаа, үйлчилгээг төрийн болон ТББ-уудтай хамтран хэрэгжүүлэх



ЗОРИЛГО (ҮР ДҮН) 4: САЙН ДУРЫН ИДЭВХИТЭН, ГИШҮҮД, ДЭМЖИГЧИДДЭЭ ТУЛГУУРЛАСАН, ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ, НЭГДМЭЛ БАЙГУУЛЛАГА БАЙНА.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: ОУГБТХ-НД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭСЭХ

ЗОРИЛТ 1

Засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулж, санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- Аудитын зөрчилтэй дүгнэлт гарсан эсэх
- Санхүүгийн жилийн орлого
- Орлогын өсөлтийн хувь
- Боловсронгуй болгосон Нийгэмлэгийн дүрэм, журам, бодлого
- Хурлын шийдвэр, мэдээллийн нээлтэй байдал

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хороо, салбарын удирдах зөвлөл, сонгуулийн хурлыг тогтмол зохион байгуулж шийдвэрийн биелэлтийг хянах
- Гадаад дотоод харилцааг өргөжүүлэх
- Дүрэм, журам, бодлого, тайлан төлөвлөгөө, хурлын шийдвэр, санхүүгийн мэдээллийг нийгэмлэгийн вэб сайтад тогтмол байршуулах, гишүүдэд түгээх
- Салбарын удирдах зөвлөл, гишүүдэд сайн засаглалын чиглэлээр сургалт явуулах
- Хөрөнгө нөөц бүрдүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- Нийгмийн төлөө биенесийн үйл ажиллагаа эрхлэх ХХК байгуулах, бизнес, маркетинг, борлуулалтын ажилтантай болж бизнес, маркетинг төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
- Гадаад дотоодын хандивлагчдад төсөл боловсруулж хүргүүлэх, хэрэгжүүлэх
- -Хөрөнгө нөөц дайчлах үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулах
- Салбарууд санхүүжилтаа нэмэгдүүлэх, орон нутгаас хөрөнгө нөөц дайчлах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх болон хоорондоо туршлага солилцож идэвхтэй ажиллахад анхаарах
- Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх.

ЗОРИЛТ 2

Сайн дурынхан, гишүүд, дэмжигчдээ чадваржуулж, салбаруудаа бэхжүүлэх

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

3-аас доошгүй загвар салбартай болсон байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Эхний ээлжинд Орхон, Өвөрхангай, Төв аймгийн салбаруудыг орон тооны ажилтантай болгох, санхүү, материаллаг баазын хувьд бэхжүүлэх, гишүүдийг нь чадавхжуулах төрөл бүрийн арга хэмжээнүүд зохиох),
- Загвар салбарын удирдамж боловсруулах
- Шинэ брэнд үйл ажиллагаатай болох
- Олны танил, нэр хүндтэй болон төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг гишүүнээр элсүүлж гишүүн байхын давуу талыг сурталчлах
- Гишүүдийн ялангуяа залуучуудын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн стратеги хэрэгжүүлэх
- Салбарын тэргүүн нарыг сургалтанд хамруулж удирдлага арга зүйгээр хангах
- Салбаруудыг гадаадын байгууллагатай холбож өгөхөд зуучлах
- Салбарууд, СДИ, гишүүдийн урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох-Олон улсад туршлага судлах
- сайн туршлагыг нутагшуулах
- СДИ нарыг жилд нэг удаа сургалтанд хамруулж чадваржуулах
- Жил бүр салбаруудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж дэмжиж ажиллах
- Орон тооны ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах сургалтанд тогтмол хамруулах

ХӨРӨНГӨ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО:

Санхүүгийн нөөц, чадавхийг нэмэгдүүлэх

ЗОРИЛТУУД:

Дотоодын орлогыг 2 дахин нэмэгдүүлэх
Санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх
Хөрөнгө нөөц бүрдүүлэх чиглэлээр туршлага судлах

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дотоодын орлогын нэмэгдсэн хувь
Санхүүжилтийн эх үүсвэр / ОУБ+ЗГ+ХХ+ТББ+ХБ/ төрлөөр нэмэгдэнэ
Санхүүжилтийн эх үүсвэр тоогоор / 1 ОУБ+2 ХХ+1 ЗГ/ нэмэгдэнэ
ОУГБТХ-оос хамааралтай байдлын хувь
Хөндлөнгийн хяналтын үнэлгээ дүгнэлт зөрчилгүй байна

I. ДОТООДЫН ОРЛОГО	II. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР
<ul style="list-style-type: none"> Эмнэлгийн үйл ажиллагааг өргөжүүлэх Үйлч тоо Үйлчилгээний нэр төрөл Хүний нөөц Материаллаг нөөц 	<ul style="list-style-type: none"> Өөрсдийгөө үнэлэх /санхүүгийн нөхцөл байдал болон бусад шалгуур үзүүлэлтээр 4/ Донорын зураглал
<ul style="list-style-type: none"> Төлбөртэй сургалт Өртөөчилсэн сургалт 	<p>Боломжит доноруудтай холбогдох ОУБ /гадаад болон дотоодод байгаа/ Сангууд ХХ ЗГ/гишүүдийн бүлэг, яамд, газар/ Хувь хүмүүс</p>
<p>Бараа материал борлуулах</p> <ul style="list-style-type: none"> МСС Бусад 	<p>Англи хэл дээр багц материал боловсруулах, хэвлүүлэх /доноруудад зориулсан-амжилтын түүх, хамтрагч талын талархал/</p>
<p>ЖХАХ борлуулах</p>	
<ul style="list-style-type: none"> Гишүүдийн тоог 2 дахин нэмэгдүүлэх Төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсээр бүрдүүлэх Гадаад хүмүүсийг элсүүлэх ХХК байгуулах /Эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох / Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах Орлогын төрөл нэмэгдүүлэх 	
<p>Хандив</p>	